



СҮЛД-АУДИТ ХХК

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, АУДИТ, СУРГАЛТ
САНХҮҮГИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ, ХӨРӨНГИЙН ҮНЭЛГЭЭ

2015 ОНЫ САНХҮҮГИЙН ӨДӨР

№...15/02

УЛААНБААТАР ХОТ

ХАРААТ БУС АУДИТЫН ТАЙЛАН

Зөрчилгүй санал дүгнэлт

“Монголиа Девелопмент Ресорсес” Хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлд

Бид “Монголиа Девелопмент Ресорсес” Хувьцаат компанийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан болон мөнгөн гүйлгээний тайлан бүхий санхүүгийн тайлангууд эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Санхүүгийн тайлангуудтай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, шударгаар толилуулах үүрэгтэй. Мөн залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг хэмжээний буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд хүрэлцэхүйц дотоод хяналтыг тогтоон ажиллуулах үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Аудиторын хариуцлага

Бид гүйцэтгэсэн аудитдаа үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудад дүгнэлт гаргах үүрэгтэй. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэлээ. Эдгээр стандарт нь санхүүгийн тайлангууд материаллаг алдаагүй илэрхийлэгдсэн гэсэн зохих нотолгоог олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, ёс зүйн шаардлагуудыг баримтлан гүйцэтгэхийг биднээс шаарддаг. Аудитын ажил нь санхүүгийн тайлан дахь дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажлыг багтаадаг.

Хаяг: Улаанбаатар хот

Сүхбаатар дүүрэг 8-р хороо

11-р хороолол, GB center 502 тоот

E-mail: suld_mon@yahoo.com

gundbayer@suld-audit.mn

web: www.suld-audit.mn

Факс: 976-70118016

Гар утас: 976-99114056

976-98220935

Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн 2014 оны
12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн аудит

Санхүүгийн тайлангууд нь алдаа эсвэл залилангаас үүдэлтэй материаллаг буруу тайлагналтай байж болох эрсдэлийг үнэлэх зэрэг горимуудыг аудитор өөрийн шийдлээр сонгож авна. Тэдгээр эрсдэлийн үнэлгээг хийхэд байгууллагын дотоод хяналтын системийн үр нөлөөтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг боловсруулахын тулд санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулахтай холбоотой дотоод хяналтыг аудитор авч үздэг. Түүнчлэн аудитын ажил нь санхүүгийн тайланг бүхэлд нь үнэлэхээс гадна, удирдлагын зүгээс хийсэн тооцооллуудын ул үндэстэй байдал, баримталсан бүртгэлийн бодлогын зохистой байдлыг үнэлэх ажлыг өөртөө агуулдаг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан аудитын дүгнэлтэд хангалттай зохистой үндэслэл болж чадсан гэдэгт бид итгэлтэй байна.

Дүгнэлт

Бидний дүгнэлтээр “Монголиа Девелопмент Ресорсес” Хувьцаат компанийн санхүүгийн тайлангууд нь 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн бөгөөд шударгаар илэрхийлсэн байна.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94-р зүйлд заасан хуулийн этгээд болох “Монголиа Девелопмент Ресорсес” ХК-ийн хувь нийлүүлэгчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Сүлд-Аудит ХХК-ийн
Ерөнхий захирал, МНБ

Ч.Гүндбаяр

Ч.Гүндбаяр
УТ 10322
2867656

**МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**
2014 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2013	/төгрөгөөр/ 12/31/2014
А.ХӨРӨНГӨ		
1.Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө,түүнтэй адилтгах хөрөнгө	145,666,550.25	198,713,736.80
Дансны авлага	930,894,760.00	1,015,935,364.00
Татвар, НДШ-ийн авлага		
Бусад авлага		
Бусад санхүүгийн хөрөнгө	55,670,657.69	55,793,280.17
Бараа материал	125,364,051.71	115,927,159.96
Урьдчилж төлсөн зардал /тооцоо/	6,055,054,663.00	6,266,016,663.00
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
Эргэлтийн хөрөнгийн дүн	7,312,650,682.65	7,652,386,203.93
2.Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	3,528,462,058.01	3,304,664,674.17
Биет бус хөрөнгө	940,115,554.25	840,355,104.75
Биологийн хөрөнгө		
Урт хугацааг хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	5,382,442,782.90	3,363,105,607.90
Бусад эргэлтийн бус хөрөнгө	1,115,296,419.91	1,115,296,419.91
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	10,966,316,815.07	8,623,421,806.73
НИЙТ ХӨРӨНГӨ	18,278,967,497.72	16,275,808,010.66
Б.ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
1.Өр төлбөр		
Дансны өглөг	36,670,525.00	106,381,360.00
Цалингийн өглөг		
Татварын өр	32,958,327.35	5,468,247.50
НДШ-ийн өглөг		
Богино хугацаат зээл		
Хүүгийн өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого	12,711,090.00	
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	82,339,942.35	111,849,607.50



Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн 2014 оны
12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн аудит

Урт хугацаат зээл	1,872,989,483.25	-
Нөөц /өр төлбөр /		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,872,989,483.25	-
Өр төлбөрийн нийт дүн	1,955,329,425.60	111,849,607.50
2.Эздийн өмч		
а.Төрийн		
б.Хувийн		
в. Хувьцаат	13,750,000,000.00	13,750,000,000.00
Халаасны хувьцаа	(5,658,000.00)	(5,658,000.00)
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	896,568,750.00	549,546,875.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
Эздийн өмчийн бусад хэсэг		
Хуримтлагдсан ашиг, алдагдал	1,682,727,322.12	1,870,069,528.16
Эздийн өмчийн дүн	16,323,638,072.12	16,163,958,403.16
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	18,278,967,497.72	16,275,808,010.66

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн 2014 оны
12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн аудит

МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН
2014 оны 12-р сарын 31-ний өдрөөрх

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
	12/31/2013	12/31/2014
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
Борлуулалтын орлого (цэвэр)	652,259,023.98	857,471,370.86
Борлуулалтын орлогын дүн	652,259,023.98	857,471,370.86
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	58,311,991.03	65,408,148.79
Нийт ашиг /алдагдал/	593,947,032.95	792,063,222.07
Түрээсийн орлого		
Хүүгийн орлого	506,695,860.60	2,088,881.93
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	654,951,500.70	854,283,291.26
Санхүүгийн зардал	263,907,655.42	122,935,102.55
Бусад зардал	27,490,737.58	-
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	171,325,530.65	(165,307,587.88)
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		(30,873,920.61)
Биет бус хөфөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)	6,537,579.64	219,777,017.48
Бусад ашиг (алдагдал)	(82,567,231.64)	
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	249,588,878.50	(159,470,780.82)
Орлогын татварын зардал	50,669,586.06	(208,888.14)
Татварын дараах цэвэр ашиг (алдагдал)	198,919,292.44	(159,679,668.96)
Зогсоосонүйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	198,919,292.44	(159,679,668.96)
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн		
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	14.47	(11.62)



Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2014 оны 12-р сарын 31-ний өдөр						/төгрөгөөр/
<u>Үзүүдэлт</u>	<u>Өмч</u>	<u>Халаасны хувьцаа</u>	<u>Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл</u>	<u>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</u>	<u>Нийт дүн</u>	
2013 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	13,750,000,000.00	(5,658,000.00)	896,568,750.00	1,483,808,029.68	16,124,718,779.68	
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				198,919,292.44	198,919,292.44	
Залруулсан үлдэгдэл	13,750,000,000.00	(5,658,000.00)	896,568,750.00	1,682,727,322.12	16,323,638,072.12	
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(159,679,668.96)	(159,679,668.96)	
Бусад дэлгэрэнгүй орлого						
Өмчид гарсан өөрчлөлт						
Зарласан ногдол ашиг						
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн			(347,021,875.00)	347,021,875.00		
2014 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	13,750,000,000.00	(5,658,000.00)	549,546,875.00	1,870,069,528.16	16,163,958,403.16	

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



**МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС ХК-ИЙН
АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2014 оны 12-р сарын 31-ний өдрөөрх


ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
	12/31/2013	12/31/2014
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	685,856,956.41	903,405,170.04
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	676,599,928.00	887,410,170.04
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	9,257,028.41	15,995,000.00
Мөнгөн зарлагын дүн (-)	940,602,187.42	1,086,890,386.57
Ажиллагчдад төлсөн	255,372,076.82	258,572,815.81
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	31,672,133.77	29,990,123.40
Түүхий эд материал худалдан авахад төлсөн	60,964,234.00	67,493,942.61
Ашиглалтын зардалд төлсөн	2,455,144.73	4,274,694.18
Түлш шатахуун, тээврийн хөлс төлсөн	178,795,526.35	450,992,110.17
Хүүний төлбөрт төлсөн	263,907,655.42	122,935,102.55
Татварын байгууллагад төлсөн	129,673,358.41	99,036,564.97
Даатгалын төлбөрт төлсөн		
Бусад мөнгөн зарлага	17,762,057.92	53,595,032.88
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(254,745,231.01)	(183,485,216.53)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	299,778,964.76	2,290,382,986.30
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		40,702,534.37
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	156,998,719.64	2,247,591,570.00
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	142,780,245.12	2,088,881.93
Хүлээн авсан ногдол ашиг		
Мөнгөн зарлагын дүн (-)	(54,630,944.00)	(15,553,512.10)
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	54,630,944.00	15,553,512.10
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгаа		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	245,148,020.76	2,274,829,474.20
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	346,996,578.01	



Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн 2014 оны
12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн аудит

Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Валютын хангийн тэгшитгэлийн ашиг	346,996,578.01	
Төрөл бүрийн хандив		
Мөнгөн зарлагын дүн (-)	(211,545,365.09)	(2,038,297,071.12)
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	211,545,365.09	1,872,989,483.25
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Валютын хангийн тэгшитгэлийн алдагдал		165,307,587.87
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	135,451,212.92	(2,038,297,071.12)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	125,854,002.67	53,047,186.55
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</i>	<i>19,812,547.58</i>	<i>145,666,550.25</i>
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</i>	<i>145,666,550.25</i>	<i>198,713,736.80</i>

Хавсаргасан тэмдэглэлүүд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



АУДИТОРЫН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болгосон санхүүгийн тайланд аудит хийсэн, тодруулга, тэмдэглэл

1. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монголиа Девелопмент Ресорсес ХК нь 2006 оны 12 дугаар сарын 29-ны өдрийн “Туул Сонгино усны нөөц” нэртэйгээр 10,000.0 мянган төгрөгийн дүрмийн сантайгаар байгуулагдсан. Компанийн шинэчилсэн үнэт цаасны танилцуулга болон Компанийн дүрмийг 2010 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувь Нийлүүлэгчдийн ээлжит хуралдаанаар баталж, компанийн оноосон нэрийг Монголиа Девелопмент Ресорсес ХК болгон өөрчилж, үйл ажиллагааг хөрөнгө оруулалтын компани хэлбэрээр өөрчлөн зохион байгуулсан байна.

2010 оны 5 дугаар сарын 4-ний өдөр Монголиа Девелопмент Ресорсес ХК нэрээр 13,750,000.0 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй улсын бүртгэлийн гэрчилгээг дахин олгосон байна.

2012 оны 8 дугаар сарын 28-ны өдөр компанийн дүрмийг шинэчлэн улсын бүртгэлийн гэрчилгээндээ нэмэлт өөрчлөлт хийлгэсэн байна.

Тус компани эрх барих дээд байгууллага нь Хувь Нийлүүлэгчдийн Хурал бөгөөд Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөөт цагт нь ТУЗ эрх барих эрхтэй. ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирддаг байна.

2010 оны 10 дугаар сараас эхлэн Компани нь төлөвлөж байсан салбарууддаа хөрөнгө оруулалт хийж эхэлсэн бөгөөд өнөөдөр Эрдэнэговь ланд ХХК, Баянмонгол резиденс ХХК, Реженси ретайл ХХК болон Смарт ланд дайркт гэсэн 4 охин компанитайгаар үйл ажиллагаа явуулж орон сууц, оффис, худалдаа үйлчилгээний үл хөдлөх хөрөнгүүдийг эзэмшиж байна.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Сөүлийн гудамж-6А,
Сити Плаза, 202 тоот Скай Пост – 46, ш/х – 28

2. АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Сүлд-Аудит ХХК ба Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн хооронд 2015 оны 01 сарын 23-нд хийсэн Аудитын ажил гүйцэтгэх гэрээний дагуу бид танай компанийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ. Бидний аудитын зорилго нь Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ба Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв бэлтгэгдсэн гэдгийг батлахад оршино. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу явуулсан бөгөөд аудитын ажлын баримтууддаа үндэслэн дүгнэлт гаргасан болно.

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ТУХАЙ

Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн санхүүгийн тайлан нь Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-д нийцүүлж гарган, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар батлагдсан заавар журам маягтын дагуу бэлтгэгдсэн байна. Санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ түүхэн өртгийн, орлогод тооцоололтын, орлого зардал зохицох, тасралтгүй байх, нэмэлт тодруулгын гэсэн үндсэн зарчмуудыг баримталдаг байна.

Компани нягтлан бодох бүртгэлээ Сангийн сайдын 2000 оны 116 тоот тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу нягтлан бодох бүртгэлийн Диамонд 5.0 програм хангамжийг ашиглан аккрузель сууриар хөтөлдөг. Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлтүүдийг Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөг, мөнгөөр илэрхийлсэн байна. 2014 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд аудит хийж 1 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

- Санхүүгийн тайлан бэлтгэсэн байдал

Санхүүгийн тайлан нь Санхүүгийн байдлын тайлан, Орлогын дэлгэрэнгүй тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлангуудаас бүрдэж байна.

- Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүд


Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийг бодит үнэ цэнээр нь бүртгэдэг ба бодит үнэ цэнэ нь эерэг байгаа үед хөрөнгө, харин сөрөг байгаа үед өр төлбөр гэж бүртгэнэ. Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдийн бодит үнийн өөрчлөлтийг “Арилжааны цэвэр орлого”-д тусгана.

- Арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр

Үүсмэл санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад, арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хэрэглүүрүүдийг багтаасан арилжаалах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн хөрөнгө эсвэл өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь бүртгэнэ.

“Арилжааны цэвэр орлого”-д бодит үнийн өөрчлөлтийг тусгана. Энэ ангилалд өрийн үнэт цаас, өөрийн хөрөнгө болон голдуу ойрын хугацаанд буцаан худалдан авах эсвэл худалдах зорилгоор эзэмшиж байгаа үнэт цааснууд багтана.

Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд бодит үнээр нь тусгана. Бодит үнийн өөрчлөлтийг “Бодит үнийн өөрчлөлт нь орлого, зарлагын дансанд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн цэвэр олз гарз” дансанд бүртгэнэ. Орж ирэх эсвэл төлөх хүүг гэрээний нөхцлийн дагуу хүүгийн орлого, зардалд хуримтлуулж, ногдол ашгийн орлогыг тус ногдол ашгийг хүртэх эрх үүссэн үед нь “Үйл ажиллагааны бусад орлого”-д бүртгэнэ.



• **Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт**

Анх хүлээн зөвшөөрөхдөө “Борлуулахад бэлэн санхүүгийн хөрөнгө оруулалт” гэж ангилсан эсвэл “Бодит үнийн өөрчлөлт нь орлого зарлагын дансанд бүртгэгдэх”, “Дуусгавар хугацаа хүртэл эзэмших”, “Зээл ба урьдчилгаа” гэсэн ангилалд багтаагүй санхүүгийн хөрөнгийг хэлнэ. Эдгээрт өөрийн хөрөнгийн хэрэглүүр, хөрөнгө оруулалтын байгууллагад хийсэн хөрөнгө оруулалтууд ба мөнгөний зах зээл ба бусад өрийн хэрэгслүүд багтдаг.

Анх хүлээн зөвшөөрсний дараа борлуулахад бэлэн хөрөнгө оруулалтыг бодит үнээр нь хэмждэг. Бодит бус ашиг алдагдлыг шууд өөрийн хөрөнгөд “Борлуулахад бэлэн сан”-д хүлээн зөвшөөрдөг. Хөрөнгө оруулалтыг борлуулахад, өмнө хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан ашиг эсвэл алдагдлыг орлогын дэлгэрэнгүй тайлангийн “Үйл ажиллагааны орлого” эсвэл “Бусад үйл ажиллагааны зардал”-д хүлээн зөвшөөрнө.

• **Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө**

Компани мөнгөн хөрөнгөө Касс дахь бэлэн мөнгө (төгрөг) ба Банкны харилцах данс (төгрөг) гэж ангилан бүртгэдэг. Мөнгөн хөрөнгийг нэрлэсэн үнээр нь бүртгэлд тусгадаг. Гадаад валютаар хийгдсэн гүйлгээг тухайн үеийн Монголбанкны албан ханшаар төгрөгт шилжүүлэн бүртгэдэг. Гадаад валютын дансдын үлдэгдлийг тайлант жилийн эцэс дэх тухайн валютын хаалтын ханшаар тайлагнасан. Албан ханш ба гүйлгээний ханшны зөрүүг “Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)” дансанд бүртгэж орлого үр дүнгийн тайланд үйл ажиллагааны бус олз (гарз)-аар тайлагнадаг.

• **Авлага**

Авлагыг урьдчилан тооцоолсон боломжит үнэ цэнээр нь бүртгэлд тусгадаг. Найдваргүй авлагыг бүртгэх шууд данснаас хасах аргын дагуу авлагыг найдваргүй нь нотлогдсон үед найдваргүй авлагын зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэх ба найдваргүй болсон авлагын дүнгээр дансны авлагыг бууруулна.

• **Бараа материал**

Худалдан авсан бараа материалын өртөг нь худалдан авсан үнэ болон түүнийг худалдан авахтай холбоотой гарсан бэлтгэл ажиллагааны зардлаас бүрдэнэ. Бараа материалын бүртгэл хөтлөхдөө “байнгын систем” ашиглах ба энэ системийн үед бараа материалыг худалдан авсан болон зарцуулсан борлуулсан тухай бүрд өртгөөр нь бүртгэнэ. Бараа материалын зарцуулалтын өртөг тооцохдоо дундаж өртгийн арга ашигласан байна.

• **Үндсэн хөрөнгө ба түүний элэгдэл**

Үндсэн хөрөнгийг анхны худалдан авалтын өртгөөр нь бүртгэдэг. Үндсэн хөрөнгийн анхны өртөг нь түүнийг худалдаж авсан үнэ, олж бэлтгэхтэй холбоотой зардлууд болон ашиглалтын явцад капиталжих зардлаас бүрдэнэ. Үндсэн хөрөнгийг шулуун шугамын арга ашиглан, ашиглалтын хугацааных нь туршид элэгдүүлсэн. Хөрөнгийг бүрэн элэгдүүлж дуусах хугацааг дараах байдлаар харуулав.



Барилга байгууламжийг	10-60 жил
Машин тоног төхөөрөмжийг	5-15 жил
Тавилга эд хогшил, бусад хөрөнгийг	10 жил
Компьютер ба түүнтэй адилтгах хөрөнгийг	5 жил

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах эсвэл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг хүлээгдэхгүй болсон үед үл хүлээн зөвшөөрч, зарж борлуулах данснаас хасах үед өмнө нь үүссэн дахин үнэлгээний нөөцийг хуримтлагдсан ашиг руу шилжүүлдэг.

- **Биет бус хөрөнгө**

Биет бус хөрөнгийг анхны өртгөөр нь бүртгэдэг байна. Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацааг хөрөнгийн онцлог шинж чанарыг харгалзан тодорхойлох ба шулуун шугамын аргаар элэгдүүлдэг.

- **Өр төлбөр**

Өр төлбөр нь өнгөрсөн үйл явдлын үр дүнд бусдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага бөгөөд ирээдүйд төлөх бодит өртгөөрөө бүртгэлд тусгагддаг. Өр төлбөрийг богино хугацаат болон урт хугацаат өр төлбөр гэж ангилан балансанд тусгаж, богино хугацаат өр төлбөрийг дансны болон бусад өр төлбөр гэж бүртгэжээ.

Богино хугацаат өр төлбөрийн дансанд дансны өглөг, татвар нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг, цалингийн өглөг, бусад татварын өглөг, урьдчилж орсон орлого зэргийг бүртгэсэн байна


- **Татвар тооцолт**

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17.1-д заасны дагуу аж ахуйн нэгж байгууллагууд 3 тэрбум хүртэл төгрөгийн татвар ногдуулах орлогод 10%-иар, 3 тэрбум төгрөгөөс дээш орлогод 25%-иар аж ахуйн нэгжийн орлогын албан татвар тооцож төлөх шатлалын дагуу татварын тооцоог хийж улсын төсөвт төлдөг байна.

Хувь хүний орлогын албан татвар Монгол улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 23.1-д заасны дагуу ажилчдын цалингаас 10 %-иар татвар суутган авч орон нутгийн төсөвт төлдөг.

Нийгмийн даатгал Монгол улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу ажиллагчдад олгохоор тооцсон цалингаас 10%, байгууллага ажилчдад 11%-иар, нийт 21%-иар нийгмийн даатгалын шимтгэл төлдөг.

Нэмэгдсэн өртгийн албан татвар Монгол улсын Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 11.1-д заасны дагуу компани импортолсон буюу экспортолсон бараа юмуу борлуулалтын орлого 10.0 сая төгрөгт хүрсэн өдөр нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлнэ. Нэмэгдсэн өртгийн албан татварыг борлуулалтын орлогын дүнгээс 10 %-иар тооцдог.



Борлуулалтын орлогоосоо НӨАТ төлөхөөс гадна худалдан авсан бараа үйлчилгээндээ төлсөн НӨАТатвараа төлөх татвараасаа суутган тооцдог. НӨАТ-ын тайлангаа сараар тайлагнаж татварын албатай тооцоогоо хийсэн байна.

- **Орлогыг хүлээн зөвшөөрөх**


Эдийн засгийн үр ашиг нь компанид орох магадлалтай болсон ба орлогыг бодитойгоор хэмжих боломжтой болсон үед орлогыг хүлээн зөвшөөрдөг. Орлого нь НӨАТ болон бусад татвар хөнгөлөлт, урамшууллыг хассан цэвэр бодит үнэ цэнээр хэмжигддэг. Үндсэн ба үндсэн бус үйл ажиллагааны орлогыг аккруэль сууриар бүртгэдэг. Хүүгийн орлого хүү нь үр ашигт хүүгийн аргаар хуримтлагдаж бүртгэгдэнэ.

- **Хувь нийлүүлсэн хөрөнгө**

Хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаат капитал, дахин үнэлгээний нэмэгдэл, хуримтлагдсан үр дүнгээс бүрддэг. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл болон хуримтлагдсан үр дүнгийн дансдууд нь санхүүгийн тайланд анхны буюу түүхэн ханшаар тайлагнагдсан байна.

- **Өртөг, Зардал**

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагаатай холбогдон гарсан бүх зардлыг орлогын дэлгэрэнгүй тайланд тусгадаг бөгөөд эдгээр зардлыг аккруэль сууриар бүртгэдэг байна .



**МОНГОЛИА ДЕВЕЛОПМЕНТ РЕСОРСЕС ХК-ИЙН 2014 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

1. МӨНГӨН ХӨРӨНГӨ

Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх мөнгөн хөрөнгө дараах байдалтай байна.

Үзүүлэлт	2013.12.31	2014.12.31
		/ төгрөг /
Кассан дахь бэлэн мөнгө /төгрөг/	6,062,467.00	406,680.00
Кассан дахь бэлэн валют /USD/	6,637.36	0.00
Кассан дахь бэлэн валют /юань/	359,700.07	0.00
Кассан дахь бэлэн валют /фүнт/	80,878.98	0.00
Кассан дахь бэлэн валют /евро/	9,155.24	0.00
Кассан дахь бэлэн валют /гүрж жел/	69,242.40	0.00
Кассан дахь бэлэн валют /гонгконг доллар/	12,839.40	0.00
Бэлэн мөнгөний дүн	6,600,920.45	406,680.00
Капитрон банк 3009002772 MNT	147,691.12	139,691.12
Капитрон банк 3053002634 USD	4,430.44	0.00
Капитрон банк 3053002900 CNY	21,393.49	15,479.03
Капитрон банк 3053003174 MNT	1,005,249.24	1,065,034.77
ХААН Банк 5003474187 MNT	867,832.15	0.00
Хаан банк картын данс 537151440004487 MNT	3,872,439.24	0.00
ХААН Банк 5038016921 MNT	989,056.15	40,579,759.39
ХААН Банк 5038016932 USD	998,939.27	6,886,324.34
Хаан банк кредит картын данс 50380900057873 USD	4,262,180.72	0.00
Төрийн банк 34130006250 MNT	69,233,647.33	138,296,876.06
Төрийн банк 34130005800 MNT	115,473.95	0.00
Төрийн банк 34130006360 MNT	209,556.52	0.00
Төрийн банк 34130006140 MNT	209,600.40	0.00
Төрийн банк 34130272580 USD	56,052,389.05	10,486,952.96
Төрийн банк 34130271400 USD	222,982.11	0.00
Голомт банк 1102945015 MNT	374,076.59	362,076.59
Голомт банк 1103002607 CNY	26,276.45	16,790.46
Чингис хаан банк 3920110013 MNT	410,932.08	410,932.00
Чингис хаан банк 3920140013 USD	41,483.50	47,140.00
Бэлэн бус мөнгөний дүн	139,065,629.80	198,307,056.80
Нийт мөнгөн хөрөнгийн дүн	145,666,550.25	198,713,736.80

Бэлэн болон бэлэн бусаар төлбөр тооцоог хийж байна. Монголиа Девелопмент Ресорс ХК нь нийтдээ 19 харилцах данстай бөгөөд 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр эдгээр дансдын санхүүгийн бүртгэл дэхь үлдэгдэл нь байршиж буй банкуудаас авсан дансны гүйлгээ үлдэгдлийн баталгааны дүнтэй тохирч байна. Валютаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдлүүдийг 2014 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Монгол банкны албан ханш 1885 төгрөг 60 мөнгөөр валютын ханшийг тэгшитгэн орлогын дэлгэрэнгүй тайланд валютын ханшийн өөрчлөлтөөс үүссэн хэрэгжээгүй олз/гарз/-аар тусгасан байна.



2. АВЛАГА

	2013.12.31	/ мян.төгрөг / 2014.12.31
Дансны авлага		11,451.0
Ажилчдаас авах авлага	4,495.9	4,050.0
Хувь хүмүүсээс авах авлага	953,355.0	957,389.5
Компани хоорондын авлага	540.0	270.0
Байгууллага хоорондын авлага	152,452.5	222,723.6
НӨАТ-ын авлага	105,755.8	
Найдваргүй авлын нөөц	179,948.7	179,948.7
Авлагын дүн	930,894.7	1,015,935.4

Өмнөх онуудын авлагын үлдэгдлээс “Морьт Импэкс” ХХК-ийн төлөгдөөгүй ба шийдвэрлэг - дээгүй 1,107,540.1 мянган төгрөгийн он дамжсан авлагаас 2012 онд Улаанбаатар-Аудит Корпораци ХХК-ийн аудитын залруулгаар 179,948.7 мянган төгрөгийн найдваргүй авлагын хасагдуулга хийж бууруулсан авлага тайлант онд төлөгдөөгүй байна. Дансны авлагаас 65,997.5 мянган төгрөгийн тооцоо нь 2013 оны авлагын үлдэгдэл, үлдэгдэл 22,346.5 мянган төгрөгийн авлага нь тухайн тайлант жилд хамаарах хугацаандаа төлөгдөж байгаа авлагууд байна.

3. БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

	2014.12.31	/ мян.төгрөгөөр /
Гадаад хувьцаагаарх хөрөнгө оруулалт	53,015.2	
Дотоод хувьцаагаарх хөрөнгө оруулалт	2,778.1	
Нийт дүн	55,793.3	

2010 оны 9-р сарын 30-нд Канадын Торонтогийн хөрөнгийн биржээс “Prophesy Resource Корпораци”-ийн 45,347 ширхэг хувьцааг 23.0 мянган канад доллар буюу 25,447.6 мянган төгрөгөөр худалдан авч байсан байна. Энэхүү хөрөнгө оруулалтыг дараах албан ханшаар илэрхийлсэн байна.

	Хувьцаа ны тоо	Хувьцаа ны үнэ	Албан ханш (CAD)	Зах зээлийн үнэ	2014.12.31 мян.төг
Prophesy Resource Корпораци	45,347	0.75	1,558.80	1169.10	53,015.2

	2014.12.31	/мян.төгрөгөөр/
Баянгол зочид буудал	348.0	
Зоос банк	1,785.3	
Нийт дүн	2,133.3	

ҮЦТТХГ ХХК дахь Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн харилцах дансны дэлгэрэнгүй хуулгад тусгаснаар дотоодын хөрөнгийн зах зээл дэх хөрөнгө оруулалт дараах байдалтай байна. Компани нь нийт 2 компанийн 2,655.5 мянган төгрөгийн 1,545 ширхэг хувьцааг эзэмшиж байна. ҮЦТТХГ-ийн дансанд 644.8 мянган төгрөг байна.

4. БАРАА МАТЕРИАЛ

/мян.төгрөгөөр/

	2013.12.31	2014.12.31
Түүхий эд материал	91.6	28.0
Бэлэн бүтээгдэхүүн	444.0	0.00
Сэлбэг хэрэгсэл	291.0	85.0
Барилгын материал	851.0	841.6
Хангамжийн материал	104,666.5	104,663.5
Хангамжийн материал/ бусад/	8,145.7	3,463.8
Сав баглаа боодол	60.0	20.0
Хангамж материал / ашиглалтанд/	5,955.7	5,241.6
Хангамж материал /Суудлын бүрээс/	360.0	360.0
Хангамж материал / ашиглалтанд/	4,498.5	1,223.6
Нийт дүн	125,364.0	115,927.1

Хангамжийн материал дансанд 103,390.0 мянган төгрөгийн хайрга бүртгэсэн байгааг түүхий эд материал дансанд шилжүүлж бүртгэх. Бусад материалууд нь байгууллагын дотоод хэрэгцээнд болон оффисын хэрэгцээний бичиг хэргийн материал мөн авто машины сэлбэг хэрэгслийг бүртгэсэн байна.

5. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ ТООЦОО

/мян.төгрөгөөр/

	2013.12.31	2014.12.31
Урьдчилгаа тооцоо	6,055,054.6	6,266,016.7
Нийт дүн	6,055,054.6	6,266,016.7

2013 оны 12 дугаар сарын 26-ны ҮХЭХ худалдан авах гэрээний дагуу СБДүүрэгт байрлалтай Реженси Резиденс байрны зүүн жигүүрийн 2 болон 3-р давхарын 1740 м.кв талбай бүхий үйлчилгээний зориулалттай ҮХЭХөрөнгийг авахаар төлөвлөж гаргасан урьдчилж төлсөн тооцоо байна.

6. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

/мян.төгрөгөөр /

	Барилга байгууламж	Машиин тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт хөрөнгө
ӨРТӨГ							
2013 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	3,214,340.4	370,482.5	115,325.4	203,688.1	31,800.1	30,618.6	3,966,255.1
Нэмэгдсэн				9,331.4	6,222.1		15,553.5
Хасагдсан				118,991.7	16,303.1	13,106.0	148,400.8

21

Монголиа Девелопмент Ресорсес ХК-ийн 2014 оны
12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлангийн аудит

2014 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	3,214,340.4	370,482.5	115,325.4	94,027.8	21,719.1	17,512.6	3,833,407.8
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ							
2013 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	89,938.8	192,150.3	58,784.8	55,957.5	30,089.1	10,872.7	437,793.2
Нэмэгдсэн	81,700.8	37,028.0	11,526.2	14,241.5	1,910.9	2,449.8	148,857.2
Хасагдсан				36,953.5	16,303.2	4,650.5	57,907.2
2014 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	171,639.6	229,178.3	70,311.0	33,245.5	15,696.8	8,672.0	528,743.2
ДАНСНЫ ЦЭВЭР ҮНЭ							
2014 оны 12 сарын 31-нээрх үлдэгдэл	3,042,700.8	141,304.2	45,014.4	60,782.3	6,022.2	8,840.6	3,304,664.6

Тайлант хугацаанд 148,400.9 мянган төгрөгийн тавилга эд хогшил, компьютер техник хэрэгсэл болон бусад үндсэн хөрөнгүүд худалдсантай холбоотой 57,907.2 мянган төгрөгөөр элэгдлийн зардал буурсан байна.

7. ДУУСААГҮЙ БАРИЛГА

	/мян.төгрөгөөр/	
	2013.12.31	2014.12.31
Бусад хөрөнгө	1,115,296.4	1,115,296.4
Нийт дүн	1,115,296.4	1,115,296.4

Анх “Туул Сонгино усны нөөц” төсөл хэрэгжүүлж эхлэхэд баригдсан барилга нь дуусаагүй барилга дансанд бүртгэлтэй.

8. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

	2013.12.31	2014.12.31
Газар эзэмших эрх	940,115.5	840,355.1
Биет бус хөрөнгийн дүн	940,115.5	840,355.1

Газар эзэмших эрхийг 5 жилийн хугацаатайгаар 2010 онд анхны өртөг болох 1,497,500.0 мянган төгрөгөөр бүртгэн ашиглагдах хугацааг 15 жилээр тогтоож 2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 99,760.4 мянган төгрөгийн хуримтлагдсан хорогдлыг бүртгэсэн байна.

9. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА БУСАД ХӨРӨНГӨ

	/мян.төгрөгөөр/			
	2013.12.31	Нэмэгдсэн	Хасагдсан	2014.12.31
Хөрөнгө оруулалт	5,215,305.8		2,019,337.2	3,195,968.6
Охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	167,137.0			167,137.0
НИЙТ ДҮН	5,382,442.8		2,019,337.2	3,363,105.6

2010 онд Баян монгол хороололд худалдан авсан 30 ширхэг орон сууцны байр, охин компанид оруулсан хөрөнгө оруулалтууд бүртгэгдсэн байна. Тайлант хугацаанд 12 ширхэг орон сууцны байрыг 2,019,337.2 мянган төгрөгийн дахин үнэлсэн өртгөөр худалдан борлуулсан байна. Охин компани болох Эрдэнэсговь ланд ХХК-д 110,000.0 мянган төгрөгийн, Смартланд дайрект ХХК-д 55,000.0 мянган төгрөгийн, бусад 2 охин компанид 2,137.0 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт оруулсан байна.

10. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР

	2013.12.31	2014.12.31
Дансны өглөг	3,530.0	58,115.4
Хүмүүст өгөх өглөг	11,222.3	12,089.0
Орлогын татварын өглөг	28,726.4	155.7
Байгууллагад өгөх өглөг	21,918.2	36,177.0
НӨАТ-ын өглөг	4,231.9	5,312.5
Урьдчилж орсон орлого	12,711.1	0.00
Өглөгийн дүн	82,339.9	111,849.6

Дээрхи өглөгүүд нь түрээсийн барьцаат өглөг ба НӨАТ болон татварын өглөгүүд тусгагдсан ба тайлант хугацаандаа төлөгдөж байгаа өглөгүүд байна.

11. УРТ ХУГАЦААТ ӨГЛӨГ


	2013.12.31	Валют	2014.12.31	Валют
Банкны зээл	1,872,989.5	1,128.7	0.00	0.00
Нийт дүн	1,872,989.5	1,128.7	0.00	0.00

2014 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар урт хугацаат зээлийн үлдэгдэлгүй тайлагнагдсан байна.

12. ХУВЬЦААТ КАПИТАЛ

	2013.12.31	2014.12.31
Энгийн хувьцаа	13,750,000.0	13,750,000.0
Халаасны хувьцаа	5,658.0	5,658.0
Нийт дүн	13,744,342.0	13,744,342.0

Компанийн хувьцаат капитал хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгө болох 13,750,000.0 мянган төгрөгөөс бүрдэх ба 1,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 13,750.0 мянган ширхэг энгийн хувьцаанд хуваагдана. 2010 онд 5,658 ширхэг хувьцаа халаасласан ба тайлант хугацаанд халаасны хувьцаатай холбоотой гүйлгээ гараагүй байна.



13. ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НӨӨЦ

	2013.12.31		/мян.төгрөгөөр/ 2014.12.31
	Эхний үлдэгдэл	Хасагдсан	Эцсийн үлдэгдэл
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	896,568.8	347,021.9	549,546.9
Нийт дүн	896,568.8	347,021.9	549,546.9

Дахин үнэлгээний нөөц нь 2012 онд орон сууцны барилгуудад хийсэн дахин үнэлгээнээс үүссэн байна. 2014 онд худалдан борлуулсан 12 орон сууцны барилгын дахин үнэлгээний зөрүү 347,021.9 мянган төгрөгөөр дахин үнэлгээний нэмэгдэл данс буурсан байна.

14. ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ), НОГДОЛ АШИГ

Эхний үлдэгдэл	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	Залруулсан үлдэгдэл	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	/мян.төгрөгөөр/ Эцсийн үлдэгдэл
				1,682,727.3

15. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

	/мян.төгрөгөөр/ 2013.12.31		2014.12.31
	Борлуулалтын орлого	652,259.0	857,471.4
Нийт орлогын дүн	652,259.0	857,471.4	

Тайлант хугацаанд хөрөнгө түрээслүүлсний орлоготой ажилласан байна.

16. БУСАД ОРЛОГО

	/мян.төгрөгөөр/ 2013.12.31		2014.12.31
	Хүүгийн орлого	506,695.9	2,088.9
Гадаад валютын бодит бус ашиг	171,325.5		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн ашиг	6,537.6	265,033.3	
Бусад орлогын дүн	684,559.0	267,122.2	



17. ӨРТӨГ БА ЗАРДАЛ

	/мян.төгрөгөөр/	
	2013.12.31	2014.12.31
Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг	58,312.0	65,408.1
Цалингийн зардал	279,248.0	271,684.5
НДШ-ийн зардал	30,366.2	29,990.1
Албан татвар хураамжийн зардал	51,131.2	70,257.0
Томилолтын зардал	18,873.9	
Бичиг хэргийн зардал	4,722.8	5,591.1
Шуудан холбооны зардал	10,327.8	8,389.9
Мэргэжлийн үйлчилгээний зардал	19,627.4	59,136.3
Сургалтын зардал	1,000.0	2,776.0
Даатгалын зардал		16,501.5
Ашиглалтын зардал	2,455.1	4,274.7
Засварын зардал	3,868.3	5,158.7
Элэгдлийн зардал	254,230.0	248,617.6
Түрээсийн зардал		32,425.0
Харуул хамгаалалтын зардал	23,390.0	26,360.0
Шатахууны зардал	6,542.3	3,893.5
Хүлээн авалтын зардал	2,705.5	945.9
Зар сурталчилгааны зардал	1,299.5	4,477.1
Зээлийн хүүгийн зардал	263,908.0	122,935.1
Бусад зардал	23,785.3	63,804.3
Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртгийн дүн	58,312.0	65,408.1
Үйл ажиллагааны зардлын дүн	997,481.1	977,218.4
Нийт дүн	1,055,793.1	1,042,626.5

Нийт үйл ажиллагааны зардлын дүнд нь цалингийн зардал 27.8 хувь, НДШ-ийн зардал 3.1 хувь, албан татвар төлбөр хураамжийн зардал 7.2 хувь, мэргэжлийн үйлчилгээний зардал 6.1 хувь, бичиг хэргийн зардал 0.6 хувь, шуудан холбооны зардал 0.9 хувь, сургалтын зардал 0.3 хувь, ашиглалтын зардал 0.4 хувь, дааггалын зардал 1.7 хувь, засварын зардал 0.5 хувь, элэгдлийн зардал 25.4 хувь, түрээсийн зардал 3.3 хувь, харуул хамгаалалтын зардал 2.7 хувь, шатахууны зардал 0.4 хувь, хүлээн авалтын зардал 0.1 хувь, зар сурталчилгааны зардал 0.5 хувь, зээлийн хүүгийн зардал 12.5 хувь, бусад зардал 6.5 хувийг эзэлж байна.

18. ТАТВАР НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТАЙЛАГНАЛ, ТӨЛӨЛТ

Нийгмийн даатгал, ХХОАТ, ААНОАТ болон бусад татваруудын тайлангийн үлдэгдэл нь бүртгэл дэхь дүнтэй тохирч байна. Тайлант хугацаанд 12 орон сууц худалдсанаас үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогын татварт 45,256.3 мянган төгрөг төлсөн байна.

19. БОЛЗОШГҮЙ ӨР ТӨЛБӨР

Тус компани нь 2014 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд болзошгүй өр төлбөртэй холбоотой ажил гүйлгээ гараагүй байна.



20. ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН ГҮЙЛГЭЭ

Тайлант хугацаанд холбоотой талын гүйлгээ гараагүй байна.

21. ТАЙЛАНГИЙН ОРЧУУЛГА

Санхүүгийн тайлангууд нь монгол хэлнээ үйлдэгдсэн бөгөөд монгол хэлнээс өөр хэл дээр орчуулагдсан тохиолдолд орчуулгын ямар нэгэн алдаа гарвал монгол хэл дээрх хувилбарыг баримтална.

Хүндэтгэсэн,

Ч.Гүндбаяр
Ахлах аудитор

С.Лхагважав
Аудитор